



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2020. 01. 06 № 04/40
танай _____-ны № _____-т

Удирдамж хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг Даргын 2019 оны А/1343 дугаар захирамжаар батлагдсан “Нэг хот – Нэг стандарт” болзолт уралдааны удирдамжид заасны дагуу нийслэлийн хороод, хэсгийн ахлагч нарын илрүүлсэн зөрчлийн мэдээллийн дагуу хариуцсан чиг үүргийн хүрээний зөрчлийг шуурхай арилгах талаар төлөвлөгөө боловсруулж арга хэмжээ авч ажиллана уу.

Болзолт уралдаантай холбоотой асуудлаар төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Ц.Баттулга-тай харилцана уу.

Хавсралтаар “Нэг хот – Нэг стандарт” болзолт уралдааны удирдамжийг хүргүүлэв.

Хавсралт 15 хуудастай.

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА**



Ү.ГАНБОЛД



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/1343

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 30 дугаар зүйлийн 30.1.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хотын стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, төрийн албан хаагч болон хэсгийн ахлагч нарын стандарт, норм, дүрмийн талаар мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор “Нэг хот - Нэг Стандарт” болзолт уралдааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Болзолт уралдааныг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, улирал, жил бүр дүгнэж, тайлан дүн мэдээг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга /Э.Содномжамц/-д даалгасугай.

3. Болзолт уралдаан, түүний үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/491 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111020000095

Нийслэлийн Засаг дарга 2019 оны
...сарын ... өдрийн
А/1343... захирлын хэвлэлт

“НЭГ ХОТ - НЭГ СТАНДАРТ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Үндэслэл: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж, хотын стандартыг нэвтрүүлэх замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулахад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагад үндэслэв.

1.2.Зорилго: Дүүрэг, хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарын олон улсын болон үндэсний стандарт, норм, дүрмийн талаар мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх замаар хотын стандарт, норм, дүрэм хэм хэмжээ мөрдүүлэхэд дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд стандарт, хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийслэлийн Засаг даргын шийдвэрүүд, норм, дүрэм, хэм хэмжээг мөрдүүлэх, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах, ажлын шинэ санал санаачилгыг дэмжих замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү болзолт уралдааны зорилго оршино.

1.3.Хамрах хүрээ, хугацаа: Болзолт уралдааныг нийслэлийн 9 дүүрэг, 173 хороодын дунд жил бүрийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31 –ний өдрийн хооронд зохион байгуулна.

1.4.Шалгаруулалт: Болзолт уралдааны хүрээнд улирал бүр тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийг, жилийн эцэст шилдэг дүүрэг, шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг багийг шалгаруулна.

Хоёр. Болзолт уралдаанд оролцогчид, хамтын ажиллагаа

2.1.Болзолт уралдааныг нийслэлийн хэмжээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулсан нийслэлийн Ажлын хэсэг удирдан зохион байгуулна.

2.2.Нийслэлийн Ажлын хэсэг нь болзолт уралдаан эхэлсэн өдрөөс дүгнэх өдөр хүртэлх хугацаанд хороо, хэсгийн ахлагч нарын багийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий Төрийн бус байгууллага /цаашид хөндлөнгийн үнэлгээний байгууллага гэх/-тай хамтран ажиллана.

2.3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд / цаашид байгууллага гэх / -ууд хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар дүүрэг, хороод, хэсгийн ахлагч нарын багийн үйл ажиллагаанд удирдамжид заасны дагуу дэмжлэг үзүүлэх, үнэлгээ өгөх, үнэлүүлэх хэлбэрээр хамтран ажиллана.

2.4.Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар нь стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр дүүрэг, хороо, байгууллагуудаас хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч дэмжлэг туслалцаа үзүүлэх,

<http://www.manaikhoroo.mn> цахим системээр дамжуулан ирүүлсэн зөрчил, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавьж тайланг 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайланг харгалзан 03 дугаар сарын 15, 06 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 15, 12 дугаар сарын 15 -ны өдрийн дотор нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

2.5.Байгууллагууд хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчлийг таних, илрүүлэх, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах, ажлын шинэ санал санаачилгыг дэмжих зэрэг чиглэлээр дүүрэг, хороо, хэсгийн ахлагч нарт зориулсан сургалтын агуулгыг боловсруулж нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн сургалтын төвд хүргүүлж, баталгаажуулж, "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын цахим сургалтын систем" /erp.ulaanbaatar.mn -> СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ/ -д байршуулсан байна.

2.6.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн сургалтын төв нь дүүрэг, хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг идэвхжүүлэх, зорилгоор байгууллагуудаас ирүүлсэн сургалтын агуулгын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалт, семинар зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж нийслэлийн Ажлын хэсгийн даргаар батлуулж, зохион байгуулна.

2.7.Байгууллагууд хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар дүүрэг, хороодоос <http://www.manaikhoroo.mn> цахим системээр дамжуулан ирүүлсэн санал хүсэлт, илрүүлсэн зөрчлийн мэдээллийг хүлээн авч 30 хоногийн дотор шийдвэрлэн эргэн мэдээлэх чиглэлээр бүх түвшинд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

Гурав. Болзолт уралдааны зохион байгуулалт, үнэлгээ

3.1.Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэхтэй холбоотой хэсгийн ахлагч нарын багийн илрүүлсэн бодит зөрчил, түүнийг мэдээлэх, арилгах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чанар, үр дүнг харгалзан үнэлгээ өгч 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайланг харгалзан 03 дугаар сарын 15, 06 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 15, 12 дугаар сарын 15 -ны өдрийн дотор нийслэлийн Ажлын хэсэгт баталгаажуулан ирүүлнэ.

3.2.Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь хороод стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчил дутагдлыг арилгах, хяналтын тогтолцоог сайжруулах, бүртгэл мэдээллийн баяжилт, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн ажлын чанар үр дүнд үнэлгээ өгч 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайланг харгалзан 03 дугаар сарын 15, 06 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 15, 12 дугаар сарын 15 -ны өдрийн дотор нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

3.3.Байгууллагууд нь нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн сургалт, судалгааны төвтэй хамтран 1) дүүрэг, хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг идэвхжүүлэх, зорилгоор зохион байгуулсан мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалт, семинарын үр дүн, 2) хороодоос ирүүлсэн зөрчлийн мэдээллийн шийдвэрлэлт, 3) хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар стандарт, норм, дүрэм, хэмжээг мөрдүүлэх, сайжруулах, шинээр боловсруулах талаар хэрэгжүүлсэн тухай 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайланг харгалзан 03 дугаар сарын 15, 06 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 15, 12 дугаар сарын 15 -ны өдрийн дотор нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

3.4.Хороод нь хэсгийн ахлагч нарын хотын стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, хяналт тавихтай холбоотойгоор илрүүлсэн зөрчлийн мэдээллийг <http://www.manaikhoroo.mn> цахим системд оруулах, зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.5.Нийслэлийн Ажлын хэсэг нь энэхүү удирдамжийн 3.3 зүйлд заасан тайлан, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг харгалзан 1, 2, 3, 4 дүгээр улирлын үнэлгээг харгалзан 03 дугаар сарын 20, 06 дугаар сарын 20, 09 дүгээр сарын 20, 12 дугаар сарын 20 -ний өдрийн дотор гаргана.

3.6.Нийслэлийн Ажлын хэсэг нь байгууллагууд хотын стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр хороодтой хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах сургалт семинарын бодит үр дүн, үр нөлөөг тооцох зорилгоор байгууллагуудад, дүүрэг, хороо, хэсгийн ахлагч, иргэдээс 1, 2, 3, 4 дүгээр улирлын хэрэглэгчийн үнэлгээг харгалзан 03 дугаар сарын 15, 06 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 15, 12 дугаар сарын 15 -ны өдрийн дотор зохион байгуулна.

3.7.Тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний баг шалгаруулах тухай

3.7.1.Болзолт уралдааны хүрээнд улирал бүр тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийг шалгаруулж хороодын үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлсэн байгууллагуудыг шагнаж урамшуулна.

3.7.2.Нийслэлийн Ажлын хэсэг нь хороодод хөндлөнгийн үнэлгээний байгууллагын өгсөн үнэлгээний хамгийн өндөр үнэлгээтэйг нь сонгох замаар улирал бүр тэргүүний хороо 10 -ыг шалгаруулж, удирдамжийн 6.1 дүгээр зүйлд заасан хугацаанд урамшууллыг олгоно.

3.7.3.Нийслэлийн Ажлын хэсэг нь хэсгийн ахлагч нарын багт хөндлөнгийн үнэлгээний байгууллагын өгсөн үнэлгээний хамгийн өндөр үнэлгээтэйг нь сонгох замаар улирал бүр хэсгийн ахлагч нарын тэргүүний баг 10 -ыг шалгаруулж, удирдамжийн 6.1 дүгээр зүйлд заасан хугацаанд урамшууллыг олгоно

3.7.4.Нийслэлийн Ажлын хэсэг нь байгууллагуудад хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарын өгсөн үнэлгээ ба 3.5 дугаар зүйлд заасан үнэлгээний арифметик дунджийг тооцож хамгийн өндөр үнэлгээтэйг сонгох замаар улирал бүр 5 хүртэлх байгууллагад урамшуулж олгож болох бөгөөд удирдамжийн 6.1 дүгээр зүйлд заасан хугацаанд урамшууллыг олгоно.

3.8.Шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг баг шалгаруулах тухай

3.8.1.Болзолт уралдааны хүрээнд жил бүр шилдэг дүүрэг, шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг багийг шалгаруулна.

3.8.2.Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь хэсгийн ахлагч нарын багийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхдөө хотын хөгжлийн индекс тооцох тоон үзүүлэлтүүд, холбогдох судалгаа мэдээллийг гаргах, сайжруулах, бодит байдлыг нэмэгдүүлэх, шинэчлэх, шинэлэг байдлаар зохион байгуулсан үйл ажиллагааны чанар, үр дүнг харгалзан үнэлгээ өгч, 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

3.8.3.Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь хороодын үйл ажиллагаанд үнэлгээ өгөхдөө хотын хөгжлийн индекс тооцох тоон үзүүлэлтүүд, холбогдох судалгаа мэдээллийг гаргах, сайжруулах, бодит байдлыг нэмэгдүүлэх, шинэчлэх, стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, стандартын хяналт, мэдээллийн тогтолцоог сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чанар, үр дүнг харгалзан үнэлгээ өгч, тайланг 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

3.8.4.Байгууллагууд дүүрэг, хороодын үйл ажиллагаанд хотын хөгжлийн индекс тооцох тоон үзүүлэлтүүдийг сайжруулах, мэдээллийн бодит байдлыг нэмэгдүүлэх, шинэчлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг үр дүнтэй, бүтээлч, шинэлэг байдлаар зохион байгуулах, стандарт, норм, дүрэм хэм хэмжээг тогтоох, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах, хороодын үйл ажиллагааг дэмжих, албан

хаагчдыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны чанар, үр дүнг харгалзан үнэлгээ өгч тайланг 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан нийслэлийн Ажлын хэсэгт ирүүлнэ.

3.8.5.Нийслэлийн Ажлын хэсэг нь өмнөх жилийн 4 дүгээр улирал, тухайн жилийн 1, 2, 3 дугаар улирлын үнэлгээг /үнэлгээг иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулж болно/ үндэслэн тухайн жилийн хэсгийн ахлагч нарын шилдэг багийг шалгаруулж, удирдамжийн 6.2 дугаар зүйлд заасан хугацаанд шагнал, урамшууллыг олгоно.

А.Хэсгийн ахлагч нарын баг тус бүрийн улирлын үнэлгээнүүдийн арифметик дундаж, хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээний арифметик дунджаас дахин арифметик дундаж тооцох замаар хамгийн өндөр үнэлгээтэй 10 хэсгийн ахлагч нарын багийг тодорхойлно.

Б.Нийслэлийн Ажлын хэсэг нь 3.8.5.А-д тодорхойлсон хэсгийн ахлагч нарын багийн үйл ажиллагаа, түүний бодит байдалтай газар дээр нь очиж танилцаж үнэлгээ өгөх замаар ахлагч нарын шилдэг баг 5-ыг шалгаруулна.

3.8.6.Нийслэлийн Ажлын хэсэг нь өмнөх жилийн 4 дүгээр улирал, тухайн жилийн 1, 2, 3 дугаар улирлын үнэлгээг үндэслэн тухайн жилийн шилдэг хороо шалгаруулж, удирдамжийн 6.2 дугаар зүйлд заасан хугацаанд шагнал, урамшууллыг олгоно.

А.Хороо тус бүрийн улирлын үнэлгээнүүдийн арифметик дундаж байгууллагуудаас хороодод өгсөн үнэлгээний арифметик дундаж, хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээний арифметик дунджаас дахин арифметик дундаж тооцох замаар хамгийн өндөр үнэлгээтэй 10 хороог тодорхойлно.

Б.Нийслэлийн Ажлын хэсэг нь 3.8.6.А-д тодорхойлсон хороодын үйл ажиллагаа, түүний бодит байдалтай газар дээр нь очиж танилцаж үнэлгээ өгөх замаар шилдэг хороо 5-ыг шалгаруулна.

3.8.7.Нийслэлийн Ажлын хэсэг нь өмнөх жилийн 4 дүгээр улирал, тухайн жилийн 1, 2, 3 дугаар улирлын үнэлгээг үндэслэн тухайн жилийн шилдэг дүүргийг шалгаруулж, удирдамжийн 6.2 дугаар зүйлд заасан хугацаанд шагнал, урамшууллыг олгоно.

А.Нийслэлийн Ажлын хэсэг нь 3.7.7.А-д тодорхойлсон тухайн дүүргийн хороодын үнэлгээний дундаж, байгууллагуудаас дүүрэгт өгсөн үнэлгээний арифметик дунджаас дахин дундаж тооцож хамгийн өндөр үнэлгээтэйг нь сонгох замаар шилдэг дүүрэг 3-ыг дараа жилийн 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор багтаан шалгаруулна.

3.9.Нийслэлийн ажлын хэсэг нь стандарт, норм, дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр байгууллагуудын хэрэгжүүлсэн ажлын чанар үр дүнд үнэлгээ өгч 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайланг харгалзан 03 дугаар сарын 20, 06 дугаар сарын 20, 09 дүгээр сарын 20, 12 дугаар сарын 20 -ний өдрийн дотор дүгнэнэ.

3.10.Нийслэлийн Ажлын хэсэг нь энэхүү удирдамжийн 3.5 дүгээр зүйлд заасан үнэлгээг тооцож нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ - Үнэлгээний хэлтэст хүргүүлэх бөгөөд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” -д заасны дагуу байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг тооцоход ашиглана.

3.11.Нийслэлийн Ажлын хэсэг /хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай хамтран зохион байгуулж болно/ тухайн жилийн шилдэг хороод, хэсгийн ахлагч нарын шилдэг багийн тэргүүн туршлага харилцан солилцох семинарыг зохион байгуулж, шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг багийн тэргүүн туршлагыг бусад хороодод нэвтрүүлэх

зөвлөмжийн гарын авлага боловсруулах бөгөөд гарын авлагыг хэвлүүлж нийслэлийн бүх дүүрэг, хороодод хүргүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1. Байгууллагууд хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар дүүрэг, хороодын дунд аян, болзолт уралдаан зохион байгуулж болох ба тэр нь энэхүү болзолт уралдааны дэд уралдаан гэж тооцно.

4.2. Дэд уралдааны үр дүнг зохион байгуулагч байгууллагын саналыг харгалзан тухайн байгууллагаас энэхүү удирдамжийн 3.2.4 дүгээр зүйлд заасан үнэлгээг дэд уралдааны үнэлгээний дүнгээр орлуулан тооцож болох бөгөөд байгууллагын албан ёсоор бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэнэ.

4.3. Тухайн жилийн нийслэлийн зорилттой шууд хамааралтай үзүүлэлтийг хамааралтай үнэлгээ ба бусад үнэлгээний харьцаа 40:60 /дөчийг харьцах нь жар/ байхаар тооцож болно.

4.4. Болзолт уралдааны үйл ажиллагаа, үр дүнг тооцоход шаардлагатай бол орон сууцны болон гэр хорооллын хороодын үйл ажиллагааны цар хүрээ, ажлын онцлогийг харгалзан үзэж болно.

Тав. Шагнал, урамшуулал

5.1. Болзолт уралдааны хүрээнд идэвх санаачилгатай оролцсон тухайн улирлын тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний баг, байгууллагуудыг шалгаруулж дараах тоо хэмжээгээр өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

- | | |
|--|----------------------------------|
| 5.1.1 Тэргүүний хороо | -10. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг |
| 5.1.2 Хэсгийн ахлагч нарын тэргүүний баг | -10. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг |
| 5.1.3 Байгууллагын урамшуулал | - 5. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг |

5.2. Болзолт уралдааны хүрээнд идэвх санаачилгатай оролцсон шилдэг дүүрэг, шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг багийг жилд нэг удаа шалгаруулж дараах тоо хэмжээгээр байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

5.2.1. Шилдэг дүүрэг:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 10.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 8.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 6.000.000 төгрөг

5.2.2. Шилдэг хороо:

- I дүгээр байр - 1 Өргөмжлөл, 8.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 6.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 4.000.000 төгрөг
- Тусгай байр - 2. Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

5.2.3. Хэсгийн ахлагч нарын шилдэг баг:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 8.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 6.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 4.000.000 төгрөг
- Тусгай байр - 2. Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

Зургаа. Шагнал, урамшуулал

6.1. Болзолт уралдааны хүрээнд улирал бүрийн тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийг шалгаруулж, шагнал урамшуулал олгох хугацаа.

6.1.1.Нэгдүгээр улирлын тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийн урамшууллыг 4 дүгээр сард багтаан олгоно.

6.1.2.Хоёрдугаар улирлын тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийн урамшууллыг үндэсний их баяр наадмын өмнө багтаан олгоно.

6.1.3.Гуравдугаар улирлын тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийн урамшууллыг 10 дугаар сарын 29-ний өдрийн өмнө багтаан олгоно.

6.1.4.Дөрөвдүгээр улирлын тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын тэргүүний багийн урамшууллыг дараа жилийн 1 дүгээр сард багтаан олгоно.

6.2.Болзолт уралдааны хүрээнд тухайн жилийн шилдэг дүүрэг, шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын шилдэг багийн шагнал урамшууллыг тухайн оны нийслэлийн өдөр олгоно.

Долоо. Зөрчлийн ангилал

- 1) Барилга, хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөө
 - a) Барилгын салбартай холбоотой зөрчлүүд
 - i) Барилгын норм, дүрэм журмыг дагаж мөрдөхтэй холбоотой зөрчил /шөнө оройн цагаар барилгын ажил хийгдэж байгаа талаар, барилга хоорондын зай стандарт хэмжээнд хүрэхгүй байгаа талаар/
 - ii) Барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэх, засварын ажил хийх үед орчны аюулгүй байдлыг хангах, барилгын түр хашааны MNS 5414:2014 болон холбогдох бусад стандарт, норм, дүрмийн хэрэгжилттэй холбогдох зөрчил
 - iii) Барилга барих зөвшөөрөлгүй барилга барьсан зөрчил /зөвшөөрөлгүй барилгын ажлыг зогсоох тухай/
 - b) Газартай холбоотой:
 - i) Орц, гарцтай холбоотой зөрчил
 - ii) Ой, ус, тусгай хамгаалалттай газартай холбоотой зөрчил
 - iii) Өндөр хүчдэлийн шугам доор буусан айл өрх
 - iv) Авто замын трасс буусан айл өрх
 - v) Үерийн эрсдэлд орж болохуйц нөхцөлд буусан айл өрх
 - c) Хот төлөвлөлттэй холбоотой зөрчил
 - i) Хорооллуудын замын орц, гарц сургууль, цэцэрлэг, авто зогсоолын хүрэлцээ хангамжтай холбоотой зөрчил
- 2) Зам тээвэр, дэд бүтэцтэй холбоотой зөрчил
 - a) Авто зам:
 - i) Авто замын эвдрэл, гэмтэл, засвар үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - ii) Авто замын сэтэлгээ, орц, гарц гаргахтай холбоотой зөрчил
 - b) Дулааны сүлжээтэй холбоотой зөрчил:
 - i) Дулааны шугам сүлжээний засвар үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - c) Замын хөдөлгөөн зохицуулалттай холбоотой зөрчил
 - i) Явган хүний гарц, хурд сааруулагчтай холбоотой зөрчил, хүсэлт
 - ii) Төлбөртэй авто зогсоол, түүнтэй холбоотой зөрчил
 - d) Инженерийн байгууламжтай холбоотой зөрчил
 - i) Замын ажил, шугам засварын ажил хийхдээ инженерийн байгууламжийг эвдэж гэмтээсэн тухай зөрчил
 - e) Нийтийн тээвэртэй холбоотой зөрчил
 - i) Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - ii) Автобусны буудлын тохижилт, мэдээллийн самбартай холбоотой зөрчил
 - iii) Автобусны чиглэл маршрут, буудал дээрх зогсолт, хүлээлгийн хугацаатай холбоотой зөрчил
 - f) Цахилгааны шугам сүлжээтэй холбоотой зөрчил
 - i) Шинээр цахилгаан сүлжээнд холбуулах хүсэлтийн тухай
 - ii) Цахилгааны шугамын хүчдэл муу байгаа тухай

- 3) Орон сууц, нийтийн аж ахуй, Сууц өмчлөгчдийн холбоотой зөрчил
 - a) Орон сууц нийтийн аж ахуй:
 - i) Орон сууцны конторын үйл ажиллагаатай холбоотой зөрчил
 - ii) Шугамын засвар үйлчилгээ, айлуудын засвар үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - iii) Халаалт, дулааны доголдол, гэмтэл саатал
 - b) Сууц өмчлөгчдийн холбоотой зөрчил:
 - i) СӨХ-ны үйл ажиллагаатай холбоотой зөрчил
 - ii) Цэвэрлэгээ, лифтний засвар үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - iii) Бусад /байранд олон нохой, муур үржүүлгийн чиглэлээр тэжээж, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж байгаа тухай/ зөрчил
- 4) Хүрээлэн буй орчин, тохижилт үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - a) Агаарын бохирдолтой холбоотой зөрчил
 - i) Сайжруулсан шахмал түлшний хүрэлцээ хангамж, борлуулалт холбоотой зөрчил
 - ii) Түүхий нүүрс болон стандартын бус түлштэй холбоотой зөрчил
 - iii) Түүхий нүүрсний хэрэглээ, түлшний карт тараалттай холбоотой зөрчил
 - iv) Сайжруулсан шахмал түлшийг үнэ нэмэн дамлан борлуулж байгаа тухай зөрчил
 - b) Байгаль хамгааллын тухай:
 - i) Нийслэлийн зуслангийн ногоон бүсэд зөвшөөрөлгүйгээр газар ухах, мод булгалах, гол горхины голдирол өөрчилсөн тухай зөрчил
 - ii) Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт, түүнтэй холбоотой зөрчлүүд
 - c) Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын тухай:
 - i) Гудамж, талбайн гэрэл эвдэрсэн, асахгүй зэрэг зөрчил
 - ii) Гудамж, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээтэй холбоотой зөрчил
 - iii) Явган хүний зам, түүнийг хийх, ашиглах, засварлах, арчлахтай холбоотой зөрчил
 - iv) Явган хүний замыг хааж барьсан рекламны самбар, хашаа хайс түүнтэй холбоотой зөрчил
 - v) Орон сууц хороолол, гэр хороолол, зуслангийн бүсэд авто замын орц, гарц, яаралтай тусламжийн үеийн авто тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх бололцоогоор хангаж ажиллахтай холбоотой зөрчил
 - d) Орчны бохирдол, хог хаягдалтай холбоотой зөрчил:
 - i) Хог тээвэрлэлт, түүнтэй холбоотой зөрчил
 - ii) Хөрс, ус орчны бохирдолтой холбоотой зөрчил
 - iii) Золбин муур, нохой, түүнтэй холбоотой зөрчил
 - iv) Нийтийн бие засах газар, түүнтэй холбоотой зөрчил
 - v) Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийг зориулалтын бусаар өөрчилсөн тухай зөрчил
 - vi) Авто машин угаалгын газар, бохир устай холбоотой зөрчил
 - e) Гудамж зам талбай:
 - i) Гудамж, зам, талбайн хаягжуулалт, түүнтэй холбоотой зөрчлүүд
 - ii) Гудамж талбайн гэрэлтүүлэг, түүнтэй холбоотой зөрчлүүд
 - iii) Хашаа, хайс түүнтэй холбоотой зөрчлүүд
 - iv) Гэрлэн чимэглэл, хаяг, зар сурталчилгааны болон мэдээллийн самбартай холбоотой зөрчлүүд
 - v) Хөшөө дурсгал, архитектурын жижиг байгууламжийн арчлалт, хамгаалалттай холбоотой зөрчлүүд
 - vi) Гар дээрх ир задгай худалдаа наймаатай холбоотой зөрчил
 - f) Байгал орчин, нөхөн сэргээлттэй холбоотой зөрчил
- 5) Нийгмийн хөгжил, нийгмийн хамгаалалтай холбоотой зөрчил:
 - a) Хүүхэд осол гэмтэлд өртөж болзошгүй байршлууд
 - i) Цэцэрлэг, сургууль, тоглоомын талбай орчмын бүс
 - ii) Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, авто замын тэмдэг, тэмдэглэгээ, гарц, гэрэл дохио, хурд сааруулагч, анхааруулга санамж бүхий

- тэмдэг байрлуулах, шаардлагатай газруудад хайс хашлага байрлуулах, орчны тохижилтын стандарт, норм, дүрмийн хэрэгжилттэй холбоотой зөрчил
- iii) Шинээр баригдаж байгаа сургуулийн барилга, өргөтгөлүүд, түүний орчин
- b) Нийгмийн халамж, үйлчилгээний тухай:
- i) Ажлын байр
- c) Хөдөлмөр эрхлэлтийн талаар:
- i) Хөдөлмөр зуучлалтай холбоотой зөрчил
- ii) Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөрчил
- d) Хүүхэд гэр бүлийн тухай:
- i) Харах хандах хүнгүй, өнчин, гэр оронгүй хүүхдүүдэд зориулсан сургууль, цэцэрлэгт хамруулдаг нэгдсэн төв байгуулах хүсэлт
- e) Эрүүл мэндийн салбарын тухай: /547/
- i) Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын харилцаа хандлага, ёс зүй, үйлчилгээтэй холбоотой зөрчил
- ii) Дүүргүүдийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, салбар амбулаторийн эмчилгээ, үйлчилгээ, эмч, сувилагчдын ёс зүйтэй холбоотой зөрчил
- iii) Хөнгөлөлттэй эмийн жор, түүнтэй холбоотой зөрчил
- iv) Хувийн эмийн сангуудын үйл ажиллагаатай холбоотой зөрчил
- 6) Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай /1062/
- a) Гэрийн тэжээвэр амьтан, вакцинжуулалт, түүнтэй холбоотой зөрчил
- a) Мэдээллийн технологийн тухай: /2 /
- i) Дотоод сүлжээ, цахим системүүд, тэдгээрийн аюулгүй хэвийн ажиллагаатай холбоотой зөрчил
- ii) Стандартын шаардлага хангаагүй эсвэл ажилладаггүй, эвдрэлтэй теле хяналтын камер
- iii) Камержуулах шаардлагагай байршлууд
- b) Онцгой байдалтай холбоотой: /6/
- i) Гамшгийн эрсдэл, түүнтэй холбоотой зөрчил
- ii) Гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй холбоотой зөрчил
- c) Хяналт, шалгалт:
- i) Бараа, бүтээгдэхүүний чанар, түүнтэй холбоотой зөрчил
- ii) Хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой зөрчил
- iii) Нийтийн орон сууцны зориулалттай байранд зориулалтын бус үйл ажиллагаа явуулах, түүнтэй холбоотой зөрчил
- d) Аюулгүй байдалтай холбоотой зөрчил:
- i) Стандартын шаардлага хангаагүй цахим, тоглоомын газар
- ii) Цахилгааны ил задгай утас, түүнтэй холбоотой зөрчил
- iii) Орой үдэш, шөнийн цагаар ажилладаг эсвэл зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй цахим, тоглоомын газар
- iv) Бохирын цооног ба нүхэн жорлонгийн ариутгал, халдваргүйжүүлэлттэй холбоотой зөрчил
- v) Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил
- vi) Хүчирхийлэлд өртөж болзошгүй хүн, хүүхэд
- vii) Ахуйн хэрэглээний зуух, стандартын шаардлага, түүнтэй холбоотой зөрчил
- 7) Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай
- a) Үйлдвэрлэлийн тухай:
- i) Үйлдвэрүүд иргэдийн амьдарч буй газартай ойрхон байгуулагдсанаас болоод маш их дуу, чимээ, муухай үнэр гаргах гэх мэт хэлбэрээр иргэдийн аюулгүй тайван орчинд амьдрах эрх зөрчигдсөн зөрчил
- b) Хүнс, худалдаа, үйлчилгээний тухай:
- i) Архи согтууруулах ундаагаар үйлчилж байгаа баар, ресторонууд, стандартын шаардлага, ажиллах цагийн хуваарь түүнтэй холбоотой зөрчил
- ii) Архи согтууруулах ундаа борлуулах цэгүүд хэт ойрхон, нягтрал ихтэй байгаагаас болоод иргэд аюулгүй тайван орчинд амьдрах эрх нь зөрчигдөж байгаа тухай зөрчил
- iii) ТҮЦ-ийн үйл ажиллагаа, цэвэрлэгээ үйлчилгээ, түүнтэй холбоотой зөрчил
- 8) Бусад

Найм. Үнэлгээний маягт

ХОРООНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

..... онысарын өдөрдүүргийн-р
хороо

① байшин хороолол

② гэр хороолол

③ холимог

А. Холбогдох судалгааг гаргаж, шинэчилсэн байдал

№	Бүлэг	Үзүүлэлт	Өмнөх он	Одоо -гийн он	Үнэлгээ
	Б	В	1	2	3
1	Хүн ам	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, чанар			
2		Хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил			
3		0-5 насны хүүхдийн тоо			
4		Хаягийн бүртгэлгүй иргэдийн тоо			
5		Тэтгэвэр тэтгэмж авдаг хүний тоо			
6		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо			
7	Боловсрол	Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо			
8		Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо			
9		Хараа хяналтгүй хүүхдийн тоо			
10		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо			
11	Эрүүл мэнд	Дархлаажуулалтад хамрагдалтын хувь			
12		Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
13	Хүрээлэн буй орчин	Ил задгай үүссэн хог хаягдлын хэмжээ /тонн/			
14		Сайжруулсан ариун цэврийн байгууламжид холбогдсон айл өрхийн тоо			
15		Нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн хэмжээ			
16	Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийн тоо			
17		Хөдөлмөр эрхэлдэг гишүүнгүй өрхийн тоо			
18		Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо			
19		Түр ажлын байранд хамрагдсан иргэдийн тоо			
20	Амьжир-гааны зохистой түвшин	Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн тоо			
21		Нийтийн зориулалттай халуун усны газрын тоо			
22	Аюулгүй байдал	Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг ААНБ-ын тоо			
23		Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо			
24		Гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоо			
25		Стандартын шаардлага хангасан теле хяналтын камерын тоо			
26		Гудамж талбайн хаягжилтын хувь			
27	Агаарын бохирдол	Стандартын шаардлага хангасан зуухтай өрхийн тоо			
28		Стандартын шаардлага хангасан шүүлтүүртэй өрхийн тоо			

29		Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо			
30		Цахилгаан халаагуурт шилжсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо			
31		Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо			
32		Хийн болон бусад эх үүсвэр ашиглан түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо			
33		Цахилгаан халаалттай өрхийн тоо			
34		Бүсэд мөрдөх журам зөрчиж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо			
35		Зөрчил арилгасан тоо /Өөрсдөө болон холбогдох байгууллагад мэдээлж хамтран шийдвэрлэсэн			
36		Дулаалга хийсэн өрхийн тоо			
37		Шахмал түлшний борлуулалтын цэгийн тоо			
38	Дэд бүтэц	Хорооны хатуу хучилттай авто замын хэмжээ /км/			
39		Хорооны хатуу хучилттай явган замын хэмжээ /м/			
40		Баталгаат ус түгээх цэгийн тоо			
41		Цахилгаан эрчим хүчний хангамжтай өрхийн тоо			
42		Аюултай бүсэд оршин сууж буй өрхийн тоо			
А бүлгийн дундаж оноо					

Холбогдох судалгааг гаргаж, шинэчилсэн байдлыг үнэлэхдээ дээрх хүснэгтэд дурдсан 42 үзүүлэлтийн 2018 он болон 2019 онд хүрсэн түвшнийг харьцуулан үнэлэх бөгөөд анхан шатны мэдээллийг үнэн зөв, бодитой бүрдүүлсэн эсэхийг харгалзан хөндлөнгийн үнэлгээг өгнө. Дүгнэхдээ 5 онооны интервалтай 20-100 хүртэл оноо өгнө. А бүлгийн дунджийг дараах томъёогоор бодно.

$$\bar{A} = \frac{\bar{Y}_1 + \bar{Y}_2 + \dots + \bar{Y}_{42}}{42}$$

Б. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал

№	Бүлэг	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Албан хаагчийн чадавх	Хорооны ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт	
2		Албан хаагчдын гаргасан шинэ санал, санаачилга	
3	Иргэдийн оролцоог хангах	Иргэний оролцоотой шийдвэрлэсэн асуудлууд хэрэгжүүлсэн төсөл	
4		Хорооны үйл ажиллагааны чанар, иргэдэд хүрч ажилласан байдал, иргэний сэтгэл ханамжийн судалгаа	
5	Иргэдэд мэдээлэл хүргэх	ОНХС-ийн талаар иргэдэд танилцуулж, сурталчлах, тэдний оролцоог дэмжих	
6		Агаарын бохирдлыг бууруулах талаар иргэдэд мэдээлэл хүргэх, сурталчлах, тэдний оролцоог дэмжих	
7		Хууль, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангах	
8	Цахимжуулалт	Мэдрэгчтэй, мэдрэгчгүй, хэвлэмэл мэдээллийн самбар ашиглалтын хувь	

9		Хорооны цахим хуудас, цахим хуудасны мэдээлэл шинэчлэлтийн хувь	
10	Дээд шатны байгууллагатай хамтран ажилласан байдал	Холбогдох байгууллагаас гарсан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байдал /нийслэл, дүүрэг/	
11	Төрийн үйлчилгээ	Мэдээ, мэдээллийн ил тод байдал	
12		Иргэд, ААНБ-ын санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал	
13		Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62-р тогтоолыг хэрэгжүүлсэн байдал	
Б бүлгийн дундаж			

Хөндлөнгийн үнэлгээг дүгнэхдээ 5 онооны интервалтай 20-100 хүртэл оноог өгнө.

Хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг дараах томъёогоор тооцно.

$$\bar{B} = \frac{\bar{Y}_1 + \bar{Y}_2 + \dots + \bar{Y}_4}{13}$$

Хорооны ерөнхий үнэлгээг дараах байдлаар тооцно.

$$\bar{E} = \frac{\bar{A} * 0.6 + \bar{B} * 0.4}{2}$$

Хорооны нэгдсэн үнэлгээ:

Үнэлгээ өгсөн:

Танилцсан: /Засаг дарга:...../
..... /Зохион байгуулагч:...../

ХЭСГИЙН АХЛАГЧ НАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

..... онысарын өдөр.....дүүргийн.-р хороо

..... -р хэсэг

① байшин хороолол

② гэр хороолол

③ холимог

А. Холбогдох судалгааг гаргаж, шинэчилсэн байдал

№	Ангилал	Үзүүлэлтүүд	Маягт	Судалгааг гаргаж, шинэчилсэн байдал	Хөндлөнгийн үнэлгээ
	А	Б	В	1	2
1	Хүн ам	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, чанар	-		
2		Хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил			
3		0-5 насны хүүхдийн тоо	-		
4		Хаягийн бүртгэлгүй иргэдийн тоо	-		
5		Тэтгэвэр, тэтгэмж авдаг хүний тоо	-		
6		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	-		
7	Боловсрол	Хараа хяналтгүй хүүхдийн тоо	-		
8		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	-		
9	Хүрээлэн буй орчин	Ил задгай үүссэн хог хаягдлын хэмжээ	ЭАБ-9		
10		Сайжруулсан ариун цэврийн байгууламжид холбогдсон өрхийн тоо	ЭАБ-10а		
11		Нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн хэмжээ	ЭАБ-1		
12	Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийн тоо	-		
13		Хөдөлмөр эрхэлдэг гишүүнгүй өрхийн тоо	-		
14		Албан бус хөдөлмөр эрхлэгчийн тоо	-		
15		Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	-		
16	Амьжиргааны зохистой түвшин	Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн тоо	Өрхийн бүртгэл		

17		Нийтийн зориулалттай халуун усны газрын тоо	-			
18	Аюулгүй байдал	Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг ААНБ-ын тоо	ЭАБ-18			
19		Гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоо				
20		Стандартын шаардлага хангасан теле хяналтын камерын тоо	ЭАБ-11			
21		Гудамж талбайн хаягжилтын хувь	-			
22	Агаарын бохирдол	Стандартын шаардлага хангасан зуух, шүүлтүүртэй өрхийн тоо	ЭАБ-4			
23		Стандартын бус түлшний хэрэглээний түвшин				
24		Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоо	-			
25		Цахилгаан халаалттай өрхийн тоо	ЭАБ-4			
26	Дэд бүтэц	Хорооны хатуу хучилттай явган замын хэмжээ	ЭАБ-3			
27		Баталгаат ус түгээх цэгийн тоо	ЭАБ-8			
28		Цахилгаан эрчим хүчний хангамжтай өрхийн тоо	ЭАБ-6			
29		Аюултай бүсэд оршин сууж буй өрхийн тоо	ЭАБ-14			
	А бүлгийн дундаж оноо					

Судалгааг гаргаж, шинэчилсэн байдлыг дүгнэхдээ 5 онооны интервалтай 20-100 хүртэл оноо өгнө. Огт байхгүй бол 0, судалгааг тогтоосон хугацаанд, аргачлал зааврын дагуу бүрэн гүйцэд шинэчилж гаргасан, баталгаажуулсан байдлыг харгалзан 100 хүртэл оноог өгнө.

Хөндлөнгийн үнэлгээг дүгнэхдээ 5 онооны интервалтай 20-100 хүртэл оноо өгнө. Тухайн судалгаа үзүүлэлтийг хэсгийн ахлагч гаргахдаа анхан шатны бүртгэлийг үнэн зөв, бодитой гаргасан эсэх, энэхүү үзүүлэлтийг сайжруулахад ямар арга хэмжээ авч ажилласан зэргийг харгалзан үзэж үнэлгээг өгнө. А бүлгийн дунджийг дараах томъёогоор бодно.

$$\bar{Y}_1 = \frac{\text{Багана1} + \text{Багана2}}{2}$$

$$\bar{A} = \frac{\bar{Y}_1 + \bar{Y}_2 + \dots + \bar{Y}_{29}}{29}$$

Б. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал

№	Үйл ажиллагааны нэр	Хөндлөнгийн үнэлгээ
2.1	Дээд шатны байгууллагын бодлого шийдвэрийг иргэд, ААНБ-уудад хүргэж буй байдал	
2.2	Хариуцсан хэсэгт шинээр хийж, хэрэгжүүлсэн ажил	
2.3	Цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж буй санал санаачилга	
2.4	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62-р тогтоолыг хэрэгжүүлсэн байдал	
	Б бүлгийн дундаж оноо	

Хөндлөнгийн үнэлгээг дүгнэхдээ 5-ын интервалтай 20-100 хүртэл оноог өгнө. Хэсгийн ахлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг дараах томъёогоор тооцно.

$$\bar{B} = \frac{\bar{Y}_1 + \bar{Y}_2 + \dots + \bar{Y}_4}{4}$$

Хэсгийн ахлагчийн ерөнхий үнэлгээг дараах байдлаар тооцно.

$$\bar{E} = \frac{\bar{A} * 0.6 + \bar{B} * 0.4}{2}$$

Хэсгийн ахлагчийн нэгдсэн үнэлгээ:

Үнэлгээ өгсөн:

Танилцсан: /Засаг дарга:...../
..... /Хэсгийн ахлагч:...../